

**ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ЦОГТБААТАРЫН АНУУЖИНГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Нэг. Гүйцэтгэлийн зорилт арга хэмжээний биелэлт							
Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх”							
1.	Гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	50%	Зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах чиглэлийг ХГГХ-д хүргүүлсэн байна. Үүнд: - Оросын Холбооны улсын Алс Дорнодын гаалийн газраас холбоо баригчийн шугамаар ирүүлсэн зөрчлийн мэдээллийн дагуу “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай” (CITES) конвенцын 2 дугаар хавсралтад орсон Соргог бөхөнгийн эврийг Монгол улсын иргэн Оросын Холбооны Улсын “Хиагт” боомтоор улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан үйлдлийг илрүүлэн эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа мэдээлэл ирсэн. Монгол Улсын иргэд өөрийн болон хөрш орны гаалийн холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдлэг, мэдээлэл хангалтгүйгээс улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон хязгаарласан бараа тээвэрлэх явцдаа хөрш орны хууль хяналтын байгууллагад саатуулагдаж эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээх тохиолдол нэмэгдэж байгаатай холбоотой зорчигч иргэдийг бусад улс орны хууль тогтоомжийг зөрчиж хуулийн хариуцлага хүлээхээс урьдчилан сэргийлэх чиглэлд анхаарч холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, гаалийн хяналт, шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулахад удирдлага арга зүйгээр ханган ажиллаж үр дүнг тайлагнах 01-2/2363, 01-2/2381 дугаартай албан бичгээр Сэлэнгэ, Дорнод аймаг дахь гаалийн газар, Хөвсгөл аймаг дахь гаалийн хороонд чиглэл хүргүүлсэн. Зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах сургалтыг зохион байгуулсан байна. Үүнд: -2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Нийслэлийн Прокурорын газартай хамтран Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн талаар болон эрх бүхий албан тушаалтны анхаарах асуудлын талаар нийт харьяа гаалийн газар хороодод чиглэл хүргүүлж сургалтыг зохион байгуулсан байна.	2025.04.15-2025.06.10	

					-2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр ГЕГ-ын Зөрчилтэй тэмцэх газраас тэмцэх газраас мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үйл ажиллагаа, хууль бус эргэлтийн талаарх бүс нутгийн болон дотоодын нөхцөл байдал, нуун далдлах арга хэлбэр энэ төрлийн гэмт хэргийн чиг хандлагийн талаар “Улаанбаатар хот дахь гаалийн газар” болон “Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар”-н алба хаагчдад мэдээлэл, сургалт зохион байгуулсан байна. Зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах сэрэмжлүүлгийг олон нийтэд хүргэсэн байна. Үүнд: - ЧХОУНБГГ-ын гаалийн хяналтын бүсээр 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр 510 грамм мансууруулах бодисыг жигнэмэгийн уутанд нуун далдалж улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан үйлдлийг таслан зогсоосон талаарх мэдээллийг сэрэмжлүүлэг болгон олон нийтэд хүргэсэн. -Монголын Үндэсний олон нийтийн телевизтэй хамтран 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр сүүлийн 3 жилийн хугацаанд зохиогчийн эрхтэй холбоотой 10 гаруй зөрчил гаалийн байгууллагад бүртгэгдсэн талаар анхааруулга мэдээллийг “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрөөр дамжуулан олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан. - CITES конвенцед орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг хууль бусаар нэвтрүүлэхэд хүлээлгэх хариуцлагын талаар сэрэмжлүүлэг мэдээг бэлтгэн ОНХА-т хүргүүлэн 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Монголын гааль цахим хуудсаар олон нийтэд түгээсэн.		
2.	Гадаад дотоодын байгууллагатай хамтран ажилласан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	50%	- 2025 онд ОХУ-ын Новосибирск хотноо зохион байгуулагдах Монгол Улсын ГЕГ болон ОХУ-ын Сибирын болон Алс Дорнодын хууль сахиулах гаалийн газрын хил орчмын бүс нутагт хамтран ажиллах асуудлаар ээлжит ажлын наймдугаар уулзалтын бэлтгэл ажлыг ханган Монголын талаас оролцох ажлын хэсэг болон уулзалтын үеэр хэлэлцэх асуудал, харилцан тохиролцох протоколын талаар холбоо баригчийн шугамаар тухай бүр харилцан солилцож тохиролцсон байна. -Оросын Холбооны Улсын ХГА-ны Сибирийн хууль сахиулах гаалийн газраас холбоо баригчийн шугамаар ирүүлсэн 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 12-22/03117 тоот албан хүсэлтийн дагуу Хууль сахиулах чиглэлээр хил орчмын бүс нутагт хамтран ажиллах асуудлаар Монгол Улсын Гаалийн ерөнхий газар болон Оросын Холбооны Улсын Сибирийн болон Алс Дорнодын хууль сахиулах	2025.04.15- 2025.06.10	

					гаалийн газрын ажлын долдугаар уулзалтын хэлэлцээрийн хүрээнд тохиролцсон Протоколын 4 дүгээр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор сургалт дадлагын ажиллагааг “хяналтын дор хүргэх” аргаар хамтран зохион байгуулахыг дэмжиж буйгаа илэрхийлэн 2025 оны 06 дугаар сарын 04-ны 01/2/2394 дугаартай албан бичгээр сургалт дадлагын ажиллагаанд оролцох Монголын талын бүрэлдэхүүний нэрс болон Монгол Улсын ГЕГ-аас нэмэлтээр оруулах саналыг хавсралтаар хүргүүлсэн. -Монгол Улсын ГЕГ болон ОХУ-ын Сибирын болон Алс Дорнодын хууль сахиулах гаалийн газар хил орчмын бүс нутагт хамтран ажиллах асуудлаар харилцан тохиролцсон протоколын 2 болон 6 дугаар заалтын дагуу сар бүр 2 талын зөрчлийн мэдээллийг харилцан шуурхай солилцож, тухай бүр ирүүлсэн зөрчлийн мэдээлэл болон МУ-ын хилийн боомтоор 2 талын иргэдийн холбогдож буй зөрчлийн мэдээллийн орчуулга болон танилцуулгыг хийж ГЕГ-ын ЗТГ-ын даргад шуурхай танилцуулсан. -Оросын Холбооны улсын Алс Дорнодын хууль сахиулах гаалийн газраас ирүүлсэн 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 13-15-5472 тоот албан бичгийг холбоо баригчийн шугамаар ирүүлсэн зөрчлийн мэдээллийг ЗТГ-ын даргад танилцуулж удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу харьяа гаалийн газар хороодод “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай” (CITES) конвенцын 2 дугаар хавсралтад орсон Соргог бөхөнгийн эврийг Монгол улсын иргэн Оросын Холбооны Улсын “Хиагт” боомтоор улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан үйлдлийг илрүүлэн эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа мэдээллийг хүргүүлж энэ төрлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэл хүргүүлсэн.		
Зорилт 2. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”							
1.	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	50%	- ОХУ-тай хил орчмын бүс нутагт хамтран ажиллах ээлжит ажлын наймдугаар уулзалтын бэлтгэл ажлыг хангаж ГХА-ны хэлтэстэй тухай бүр мэдээ мэдээллийг солилцож хамтран ажилласан байна. -Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгсөн чиг үүргийг тухай бүр шуурхай хэрэгжүүлж ажилласан.	2025.04.15-2025.06.10	
2.	Цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	50%	Тайлант хугацаанд ажиллавал зохих 41 өдөр 328 цагаас 41 өдөр 350 цаг ажилласан. Илүү 22 цаг ажилласан байна. Цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид тухай бүр бүртгүүлж ажилласан.	2025.04.15-2025.06.10	
3.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг				- Тайлант хугацаанд Авлигатай тэмцэх газраас ирсэн 1, Цагдаагийн байгууллагаас ирсэн 15, ШШГЕГ ирсэн 2 бусад ААН-ээс ирсэн 2, нийт 28 албан бичгийн хариуг хуулийн хугацаанд, холбогдох лавлагаа,	2025.04.15-2025.06.10	

үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	50%	мэдээлэл, нотлох баримтын хамтаар хүргүүлсэн байна. Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж хооронд холбогдох мэдээллийг гаргуулах, чиглэл хүргүүлэх, мэдээ тайлан гаргаж хүргүүлэх зэрэг 26 удаагийн дотоод зурвасыг хүргүүлж ажилласан байна. - Эрсдэлийн асуудал хариуцсан гаалийн улсын байцаагч нь ББ ГУБ, ХШ ГУБ, ХЦ ГУБ-ын бичиг баримт болон бараа, тээврийн хэрэгсэлд хийсэн гаалийн шалгалтын дараа программд оруулсан "Шалгалтын үр дүн"-д үндэслэж, эрсдэлийн дүн шинжилгээ хийдэг. Иймд зөрчлийн чиг үүрэгт хамаарах чиглэлээр CAIS программд "Бичиглэлийн хувьд тухайн тээврийн хэрэгслийн онцлог нуувч болгон ашиглах боломжтой газруудыг ХШГУБ оруулах талбартай болгох" гэсэн саналыг ЭУХ-т санал хүргүүлсэн байна.		
-------------------	-------------------------	---	-----	---	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Tableau – Дата аналитийн ахисан шатны сургалтад хамрагдаж, Customs 360 Dashboard дээр мэдээ тайлан гаргаж сурсан байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Сургалтад хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн байна.	2025 оны 05 дугаар сарын 28-30-ны өдөр ГЕГ-ын Мэдээлэл технологийн газраас зохион байгуулсан NOVELSOFT ХХК-ийн Tableau- Дата аналитийн ахисан түвшний сургалтад хамрагдаж сертификат авсан байна.	2025.04.15-2025.06.10	
2.	Дэлхийн гаалийн байгууллагын click.wcoomd.org веб сайтад нэвтрэн ГУБ нарын бие даан суралцах платформд гаалийн хэргийн мэдлэгээ	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Сургалтад хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн байна.	"Customs control" цахим сургалтад хамрагдаж сертификат авсан байна.	2025.04.15-2025.06.10	

	дээшлүүлэн сертификат авна.						
3.	Шинээр гарсан эрх зүйн актуудтай тухай бүр танилцан мөрдөж ажиллах.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Хууль, эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	Гаалийн асуудлаар хамтран ажиллах тухай Монгол улсын Засгийн газар, Оросын Холбооны улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Олон улсын хяналтад орсон мансууруулах төрлийн угтвар бодисын жагсаалт, Гаалийн хууль тогтоомжийн Зөрчилтэй тэмцэх хүрээнд 2025-2027 онд хамтран ажиллах тухай МУ-ын ГЕГ болон ОХУ-ын ХГА хоорондын төлөвлөгөө, Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ноогдуулах, түүнд гомдол гаргах журамтай танилцсан.	2025.04.15- 2025.06.10	
4.	Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэн TOEFL, IELTS оноо авна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Сургалтад хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн байна.	"Gegee Academy"-ын англи хэлний багш Гэрэлтуяагийн сургалтад хамрагдаж эхэлсэн байна.	2025.04.15- 2025.06.10	
5.	Нэмэлтээр сургалтад хамрагдсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Сургалтад хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн байна	- "Зөрчил бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан"-г хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Прокурорын байгууллагаас 04 дүгээр сарын 17-ны өдөр явуулсан сургалтад хамрагдсан. - 2025 оны 04 дүгээр сарын 24-нд Хууль зүй Дотоод хэргийн яаманд зохион байгуулагдсан "Кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" сургалтад хамрагдсан. - "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаалийн байгууллагын анхаарах, урьдчилан сэргийлэх асуудлууд" сэдэвт багц сургалтад хамрагдсан. - 2025 оны 05 дугаар сарын 28-30-ны өдөр ГЕГ-ын Мэдээлэл технологийн газраас зохион байгуулсан NOVELSOFT ХХК-ийн сургалтад хамрагдсан. - ЗУГ, ХШҮДАГ-аас 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр явуулсан "Гаалийн байгууллагын үйл ажиллагааны тайлагналт, анхаарах асуудал" сэдэвт сургалтад хамрагдсан.	2025.04.15- 2025.06.10	

ТАЙЛАН ГАРГАСАН:

Зөрчилтэй тэмцэх газрын
гаалийн улсын байцаагч

 / Ц.Ануужин /

2025 06 09

**ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ЦОГТБААТАРЫН АНУУЖИНГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Зөрчилтэй тэмцэх газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. “Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ.	55	8	63	
2.	Гадаад дотоодын байгууллагатай хамтран ажилласан байдал	55	8	63	
Зорилт 2. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Үүрэг даалгаврын биелэлт	55	8	63	
2.	Цаг ашиглалт	55	8	63	
3.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	55	8	63	
Дундаж оноо:				63	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Tableau – Дата аналитикийн ахисан шатны сургалтад хамрагдаж, Customs 360 Dashboard дээр мэдээ тайлан гаргаж сурсан байна.	50%	15	
2.	Дэлхийн гаалийн байгууллагын click.wcoomd.org веб сайтад нэвтрэн ГУБ нарын бие даан суралцах платформд гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэн сертификат авна.	50%	15	
3.	Шинээр гарсан эрх зүйн актуудтай тухай бүр танилцан мөрдөж ажиллах.	50%	15	

4.	Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэн TOEFL, IELTS оноо авна.	50%	15	
5.	Нэмэлтээр сургалтад хамрагдсан байдал	50%	15	
Дундаж оноо			15	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	6	
3.	Асуудал шийдвэрлэх	6	
4.	Хариуцлагатай байдал	6	
5.	Ажлын цаг ашиглалт	6	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		
Дундаж оноо		6.2	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	7
2.	Багаар ажиллах	7
3.	Харилцаа	7
Дундаж оноо		7


5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	63
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6.2
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		91.2

Үнэлгээ өгсөн:

ЗТГ-ын дарга

Нэгжийн дарга

.....


/Ж.Эрдэнэболд/

2025. 06. 10

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

ЗТГ-ын гаалийн улсын байцаагч

.....



/Ц.Ануужин/

2025. 06. 10

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

ГЕГ-ын дэд даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч

.....


/Г.Энхтайван/

2025. 06. 25

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

ГЕГ-ын Хүний нөөцийн хэлтсийн
гаалийн улсын ахлах байцаагч

.....



/Ө.Тэгшээ/

2025. 06. 25

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

ГЕГ-ын дарга

.....



/Р.Отгонжаргал/

2025. 06. 25